



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/16

Баян-Адарга сум

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 19.2.3, 19.2.4 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын “Дуурлиг” багийн “Булгийн 4-415” тоотод нутаглаж байгаа малчин Г.Бүрнээбаатарын суурь үхэрт Хэнтий аймгийн Мал Эмнэлгийн Лабораторийн 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 25-70 тоот шинжилгээний хариугаар “Цусан халдварт” өвчин оношлогдсон тул 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн хязгаарлалтын дэглэмийг тогтоосугай.

2.Голомтын бүсэд байгаа малчин Г.Бүрнээбаатарын малд нэг бүрчлэн үзлэг хийх, малын хашаа хороонд халдваргүйжүүлэлтийг чанартай хийж гүйцэтгэхийг “Ороо ухаа шандас” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч (Т.Даваахүү)-д үүрэг болгосугай.

3.Хязгаарлалтын дэглэм тогтоосон өрхийн малын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, өвчтэй малын арчилгаа, маллагаа, тэжээлийн нөхцөлд хяналт тавих,хязгаарлалтын бүс дэх үйл ажиллагааг ханган багийн Засаг даргатай хамтран ажиллахыг мал эмнэлгийн тасгийн дарга (Э.Оюунтунгалаг)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн биелэлт, хязгаарлалтын дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Н.Ганбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  БОЛЖАГВАДОРЖ